

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06  
дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар  
тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн  
журам”-ын 4 дүгээр хавсралт

<b>2025 оны жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/</b>	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагналын хугацаа</i>	2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	“Тавантолгой” ХК Регистрийн дугаар: 2016656 Улсын бүртгэлийн дугаар: 1110001005 Үнэт цаасны код: MN00TTL04580 Утас: 7535-5555, 9500-1619
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Уул уурхайн олборлолт, борлуулалт
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар, Хэрэгжүүлэгч “Солид юнити аудит” ХХК
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	52,665,200 ширхэг
<i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	Төлөвлөлтийн эдийн засагч Ч.Төрмандах Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын захирал Б.Нарантуяа
<b>1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</b>	
<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>	Санхүүгийн тайлан хавсаргав.
<i>Орлогын тайлан</i>	Санхүүгийн тайлан хавсаргав.
<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	Санхүүгийн тайлан хавсаргав.
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	Санхүүгийн тайлан хавсаргав.
<b>1.1. Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</b>	

	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар, түүнийг хэрэгжүүлэгч “Солид юнити аудит” ХХК нь 2025 оны санхүүгийн тайланд хараат бус хөндлөнгийн аудит хийж байгаа бөгөөд санхүүгийн тайлан дахь аудитын дүгнэлт бүрэн гарч дуусаагүй болно. Дүгнэлт гарсны дараа дахин хүргүүлэх болно.</p>		
1.2.	<p><i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i></p>		
	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар, түүнийг хэрэгжүүлэгч “Солид юнити аудит” ХХК нь 2025 оны санхүүгийн тайланд хараат бус хөндлөнгийн аудит хийж байгаа бөгөөд санхүүгийн тайлан дахь аудитын дүгнэлт бүрэн гарч дуусаагүй болно. Дүгнэлт гарсны дараа дахин хүргүүлэх болно.</p>		
2.	<p><i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i></p>		
2.1.	<p><i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i></p>	<p>Нийт ашгийн хувь 34.9%</p> <p>Цэвэр ашгийн хувь 25.2%</p> <p>Өөрийн хөрөнгийн өгөөж 61.0%</p>	
2.2.	<p><i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i></p>	<p>Эргэлтийн харьцаа 1.79</p> <p>Түргэн хөрвөх чадварын харьцаа 1.09</p> <p>Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа 1.05</p>	
2.3.	<p><i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i></p>	<p>Нүүрсний зах зээлийн нөхцөл байдал улс төрийн болон гадаад орчны нөхцөл байдал, дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотойгоор тогтвортой биш байгаа нь таамаг гаргахад хүндрэлтэй байна. Компанийн нүүрс экспортын үйл ажиллагаа нь Уул уурхайн биржийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу Монголын хөрөнгийн биржид 100% нээлттэй явагдаж байгаа. Өнгөрсөн жилийн байдлаар 54 удаагийн цахим арилжааг зарлаж 22 арилжаа буюу 40.7%-ийн амжилттайгаар нийт 5.3 сая.тн нүүрс худалдсан. Биржээр арилжаалсан нийт нүүрсний 24.61% эзэлж байна. Өнгөрсөн 2025 оны нөхцөл байдлыг авч үзэхэд:</p>	

		<p>1. Уурхайн үйл ажиллагаа 2-8-р сард буюу жилийн 56%-д сул зогсолттой, борлуулалт оны эхний хагасд 22.2%-тай ажилласан.</p> <p>2. Төлөвлөсөн үнээс жигнэсэн дундаж үнэ 53.7\$ буюу 37.4% бага борлуулсан.</p> <p>3. 2024 оны 10 сараас хойш 2025 оны 06 сар хүртэл -83.4\$ буюу -45.9% бууралт.</p> <p>2026 онд нийт 6.7 сая.тн нүүрс экспортод борлуулж 1.8 их наяд төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөж байгаа.</p> <p>Борлуулалтын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр хилийн нэвтрүүлэх тоо хэмжээг нэмэгдүүлэх, нүүрсний арилжааг оновчтой зохион байгуулах, тээврийн олон чиглэлийг ашиглахаар төлөвлөсөн. Авто зам, төмөр зам, жолоочгүй ухаалаг тээврийг ашиглахаар төлөвлөсөн. Түүнчлэн дан ганц Гашуунсухайт боомтоор нийлүүлэлт хийх бус Ханги чиглэлд нүүрс экспортын үйл ажиллагааг явуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>
2.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</p>	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.</p>
2.5.	<p>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</p>	<p>Тайлант хугацаанд зээл аваагүй.</p>
3.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	

	Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгээгүй.
4.	<i>Цалин урамшууллын мэдээлэл</i>
	Компанийн батлагдсан бүтэц, орон тоо, бизнес төлөвлөгөөний дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн цалин, урамшууллыг олгож ажилласан.
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>
	<p><b>ТУЗ-ийн хурал</b></p> <p>Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн “75.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.” гэж заасны дагуу Орон нутгийн өмчийн оролцоотой “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 онд 91,8 хувийн дундаж ирцтэйгээр, нийт 31 удаа хуралдаж, 73 асуудал хэлэлцэн, 86 тогтоол батлан, гүйцэтгэх удирдлагад үүрэг чиглэл өгч хэрэгжүүлэн ажилласан байна. Зөвлөлийн хурлаас баталсан тогтоол шийдвэрийг бүтцээр нь авч үзвэл:</p> <p>Удирдлага, зохион байгуулалт, бүтэц орон тооны чиглэлээр 18 тогтоол баталсан нь нийт тогтоолын 21 хувь, Ажлын хэсэг байгуулах чиглэлээр 6 тогтоол буюу 7.3 хувь, Компанийн үйл ажиллагааг дүгнэх чиглэлээр 2 тогтоол баталсан нь 2.4 хувь, Нүүрс, тээврийн үнэ, хэмжээ тогтоох чиглэлээр 13 тогтоол баталсан нь 13.4 хувь, Хэмнэлтийн горимд шилжүүлэх чиглэлээр 3 тогтоол баталсан нь 3.6 хувь, Төлөвлөгөө, журам батлах, төлөвлөгөөнд тодотгол хийх чиглэлээр 5 тогтоол баталсан нь 6.1 хувь, Зөвшөөрөл олгох чиглэлээр 16 тогтоол баталсан нь 19.5 хувь, Ногдол ашгийн чиглэлээр 1 тогтоол баталсан нь 1.2 хувь, Биржийн арилжааг дэмжих чиглэлээр 2 тогтоол баталсан нь 2.4 хувь, Чиглэл өгөх чиглэлээр 9 тогтоол баталсан нь 10.9 хувь, Урамшуулал, дэмжлэг олгох тухай 7 тогтоол баталсан нь 8.5 хувийг тус эзэлж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, хороодын үйл ажиллагааны боловсруулан шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p> <p><b>ТУЗ-ийн хороод</b></p> <p>МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 4 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг “Компанийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” - аар тус тус зохицуулдаг.</p> <p>ТУЗ нь дараах байнгын хороодтой:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нэр дэвшүүлэх хороо,</li> <li>• Аудитын хороо;</li> <li>• Цалин, урамшууллын хороо.</li> </ul>


	ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.
6.	<i>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</i>
	БНХАУ-ын Нүүрсний зах зээлийн нөхцөл байдал, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж нүүрсний үнэ 2025 оны 06 сарын 16-ны байдлаар 98.2ам.долларт хүрч 2024 оны 10 дугаар сараас хойш 83.4 ам.доллар буюу 45.9% буурсан. Дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор компанийн үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тайлант оны 2-8 дугаар сарын хугацаанд зогсоон, борлуулалтаас бусад газар хэлтсүүдийг 60%-ийн сул зогсолтод хамруулан хэмнэлтийн горимд ажилласан. 2025 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан нүүрс борлуулалтын жигнэсэн дундаж үнээс 53.7 ам.доллар буюу 37.4% бага үнээр борлуулсан үзүүлэлттэй гарсан. Тайлант оны хугацаанд Монголын хөрөнгийн бирж дээрх уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд нийт 54 удаагийн арилжааг зарласнаас 22 арилжаа буюу 40.7% нь амжилттай болсон. 2025 оны 08 дугаар сараас нүүрсний үнэ сэргэж 125-145 ам.долларын дундажтай болсон. 2025 оны эхний хагас жил биет хэмжээгээр нийт борлуулалтын 22.2% хувийг, сүүлийн хагаст 77.8%-ийг тус тус борлуулсан.
7.	<i>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</i>
	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар нийт 4030 хувьцаа эзэмшигчтэй байсан. 1. Орон нутгийн өмч - 51% 2. Ажнай корпораци ХХК – 19.78% 3. Шандас Импекс ХХК - 16.31%
8.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i>
	Тайлант хугацаанд хувьцаа нэмж гаргаагүй.
9.	<i>Ногдол ашгийн мэдээлэл</i>
	Компанийн 2024 оны жилийн эцсийн цэвэр ашиг болох 412.3 тэрбум төгрөгөөс Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 12 өдрийн Ногдол ашиг хуваарилах тухай 11 дугаар тогтоолын дагуу нэгж хувьцаанд 6,960 төгрөг буюу нийт 366.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараасан. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай 28 дугаар тогтоолын дагуу эрх бүхий

	зуучлагч байгууллагаар дамжуулан 4021 хувьцаа эзэмшигчийн 10.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараасан. 2024 оны ногдол ашгийг 100 хувь тараасан.
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:
	Овог, нэр: Шаравын Отгонбаяр Албан тушаал: "Тавантолгой" УХ-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг:  (Тамга/тэмдэг)
	Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:
	Овог, нэр: Б.Нарантуяа Албан тушаал: Санхүүгийн засаг, төлөвлөлтийн газрын захирал Гарын үсэг:  Овог, нэр: Ч.Төрмандах Албан тушаал: Төлөвлөлтийн эдийн засагч Гарын үсэг: 



**ҮЙЛ АЖИЛЛАГАА,  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2025**

## 2025 оны Монгол улсын экспорт



Монгол Улсын **ДНБ 2025** онд **өсөлт 6.8%**-д хүрч, нэрлэсэн ДНБ-н дүн **89.9 их наяд** төгрөгт хүрсэн нь 2024 оноос 11.5%-иар өссөн үзүүлэлт болов.

Эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөлсөн салбарууд:

- Уул уурхай, олборлолт: нийт өсөлтийн 1.4% эзэлж 10.6 хувь буюу 453.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн
- Аж үйлдвэр, барилга: +1.5 нэгж хувь — аж үйлдвэржилтийн идэвхжил хэвээр хадгалагдав.

Монгол Улсын 2025 оны эдийн засгийн өсөлт нь хөдөө аж ахуйн салбарын хүчтэй сэргэлт, уул уурхайн тогтвортой олборлолт болон дотоодын эрэлтэд тулгуурласан төрөлжсөн үзүүлэлттэй байлаа.


## 2025 оны Монгол улсын экспорт



Монгол Улс он гарснаас хойш 11 сарын хугацаанд **79 сая тонн** нүүрсийг **5 тэрбум** ам.доллаароор экспортолсон байна. Нүүрсний экспортын тонн тутмын **дундаж үнэ 64** ам.доллар үрчээ. Чулуун нүүрсний экспорт 73.8 сая тонн болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 200 орчим мянган тонноор, үнийн дүн 3.1 тэрбум ам.доллаароор буурсан байна.

11 сарын гүйцэтгэлээр **Гашуунсухайт** боомтоор экспортолсон нүүрсний хэмжээ **41.2 сая** **ТОНН** байна

# 2025 оны Зах зээлийн нөхцөл байдал



- Гадаад эдийн засгийн орчны тогтворгүй байдал 2026 онд үргэлжилнэ. /ОУВСан/
- АНУ болон БНХАУ-тай хийх худалдааны хэлэлцээрийн тодорхойгүй байдал гадаад орчны эрсдэлийг улам нэмэгдүүлж байна /Дэлхийн банк/





# 2025 оны Нүүрс олборлолт, хөрс хуулалтын гүйцэтгэл биелэлт



ХӨРС ХУУЛАЛТ  
(сая м<sup>3</sup>):

11.59



НҮҮРС ОЛБОРЛОЛТ  
(сая тн):

1.87




УУЛЫН ЦУЛ  
(сая м<sup>3</sup>):

12.93




ХӨРС ХУУЛАЛТЫН КОЭФ.  
(м<sup>3</sup>/тн):


6.19



# 2025 оны Нүүрс борлуулалт /МЯН.ТН/



Нүүрс борлуулалтын бүтэц, МЯН.ТН




- Дэгдэмхий бодис дунд коксжих
- 1/3 коксжих
- Дотоод


# 2025 оны Эдийн засгийн голлох үзүүлэлт




НҮҮРС БОРЛУУЛАЛТ  
/саятн/




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО  
/тэрбум төгрөг/



ЦЭВЭР АШИГ  
/тэрбум төгрөг/



ТАТВАР ТӨЛӨЛТ  
/тэрбум төгрөг/



# 2025 оны Бүтэц орон тоо




**Нийт батлагдсан орон тоо: 318**

- ТУЗ-ийн гишүүд-10
- Ажилчдын тоо-308

2025 онд гүйцэтгэлээр:

**Нийт ажилчдын тоо: 286**

- Ажиллаж байгаа: 251
  - Ажлаас чөлөөлөгдсөн: 35
- Үүнээс:
- Ажлаас чөлөөлөгдсөн: 26
  - Тэтгэвэрт гарсан: 9



# Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй



A

**АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА.** Хөдөлмөрийн чадвар алдалтгүй  
315 хоног (294,716 хүн/цаг). Нийт гэмтлийн давтамж 0.68%-тай.



B

**СУРГАЛТ.** Давган зааварчилгаа 704 хүн/цаг,  
Гэрээт компани 19,120 хүн/цаг. Нийт 19,824 хүн/цаг.



C

**БИЧИГ БАРИМТ.** Хөдөлмөрийн аюулгүй байдлын бичиг баримтын  
ISO45001:2018 стандартыг нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна.



D

**САЙЖРУУЛАЛТ.** Бүртгэлжүүлэлтийг стандартад нийцүүлэн баталгаажуулалтыг хийх.  
Бүртгэлжүүлэлтээс анализ хийн хариу арга хэмжээг тооцон урьдчилан сэргийлэх.



# Байгаль орчин, ногоон хөгжил



15 Сөрөг нөлөөллийг бууруулах 63,877,918 төгрөг

2 Нөхөн сэргээлт 1,304,380 төгрөг

4 Дүйцүүлэн хамгаалах 10,800,000 төгрөг

1 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор 50,000,000 төгрөг

**НИЙТ**  
212,593,058 төгрөг  
55 ажил

2 Түүх, соёлын өвийг хамгаалах 60,000,000 төгрөг

7 Хог хаягдлын менежмент 2,172,000 төгрөг


5 Орчны хяналт шинжилгээ 19,438,760 төгрөг

3 Удирдлага зохион байгуулалт 15,000,000 төг

## Сөрөг нөлөөллийг бууруулахад хэрэгжүүлсэн онцлох ажлууд



Дотоод орчны хяналт шинжилгээг DUSTTRAK AEROSOL MONITOR 0530 багажаар хэмжсэн үр дүн.



Төв оффисын гаднах агаарын автомат станцын агаар бохирдуулагчийн үр дүн



Ус ашигласны төлбөрт эхний 2025.10.31-ний байдлаар нийт 63,722,591 сая төгрөг төлсөн. Үүнээс:


- Замын усалгаанд 35,298,666 төгрөг,
- Үнд ахуйд 28,217,060 төгрөг,
- Мод усалгаанд 206,865 төгрөг



Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

- Ус - 6 цэгээс дээж шинжлүүлсэн
- Хөрс - 10 цэгээс дээж шинжлүүлсэн
- Агаар - 6 цэгт хэмжиж /3 төрөл тоос, 4 - төрөл агаар бохирдуулагч
- Ургамал - 10 цэгээс дата цуглуулж
- Амьтан - Цэций уул, уурхайн бүсэд хийв.

## Удирдлага, зохион байгуулалтын онцлог ажлууд



2025 оны 9 сараас сард 1 удаа "Ажлын байрны үзлэг" хийж, 212 үл нийцэл илрүүлж арилгуулсан байна.

Нийт 1,605 хүнд Байгаль орчныг хамгаалах ерөнхий мэдлэг олгох сургалт

## Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалсан онцлог ажлууд



Зэрлэг амьтдыг ундаалах Цэций уулын уст цэгийг засварлаж, тохижуулах ажлын хүрээнд "Чандиань говь" туншлэлийн "Говь түрүү" ХХК "Уулс ноён" ХХК "Улз гол" ХХК гэсэн компаниуд хийж гүйцэтгэв.




Цэций хайрхан орчмын зэрлэг амьтдад 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 3 сар хүртэлх хугацаанд 4 удаа 240 боодол өвс, тэжээл, 400 кг хужир, мараа байршуулсан.

# Байгаль орчин, Тэрбум мод




“Тавантолгой” ХК-ийн нэр дээр  
107,000 ширхэг мод  
бүртгэгдсэн.




“Шинэ Хархорум хот”  
17,000 ширхэг мод



Улаанбаатар хот  
30,000 ширхэг мод



Дундговь аймаг, Луус сум  
3,000 ширхэг мод



Өөрийн талбайд 3000ш,  
Даланзадгад 5000ш,  
Цогтцэций сум 3000ш,  
Номгон 12000ш



Шамбала 2056"-ын төсөлд  
50,000 ширхэг суулгац

# 2025 оны Аудитлагдсан санхүү байдлын тайлан /төгрөгөөр/



	2024.12.31	2025.12.31	Өсөлт ба бууралт 2024/2025	
			төгрөгөөр	Хувь
<b>ХӨРӨНГӨ</b>				
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	373,701,070,884.89	285,390,681,167.17	-88,310,389,717.72	-23.6%
Дансны авлага	47,685,035,980.09	52,217,325,742.11	4,532,289,762.02	9.5%
Татвар, НДШ-ийн авлага	4,537,003,911.17	2,665,712,237.36	-1,871,291,673.81	-41.2%
Бараа материал	219,319,588,089.11	180,738,727,114.61	-38,580,860,974.50	-17.6%
Бусад авлага	1,005,114,885.92	1,417,002,890.62	411,888,004.70	41.0%
Бусад эргэлтийн хөрөнгө	17,967,142.86	22,158,809.46	4,191,666.60	23.3%
Урьдчилж төлсөн зардал тооцоо	68,825,671,911.73	28,497,255,335.46	-40,328,416,576.27	-58.6%
Үндсэн хөрөнгө	26,577,999,980.90	23,798,617,083.30	-2,779,382,897.60	-10.5%
Биет бус хөрөнгө	6,593,329,434.69	6,263,251,662.43	-330,077,772.26	-5.0%
Биологийн хөрөнгө	43,707,142.85	41,066,190.40	-2,640,952.45	-6.0%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	434,179,457.49	434,179,457.49	0.00	0.0%
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	6,160,000,000.00	6,160,000,000.00	
<b>Нийт хөрөнгө</b>	<b>783,424,460,321.84</b>	<b>618,111,893,460.43</b>	<b>-165,312,566,861.41</b>	<b>-21.1%</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>				
Дансны өтөг	18,074,449,920.88	63,657,643,883.65	45,583,193,962.77	252.2%
Татварын өр	22,573,244,443.95	54,733,810,295.80	32,160,565,851.85	142.5%
Ногдол ашгийн өтгөл	658,515,350.94	658,515,350.94	0.00	0.0%
Урьдчилж орсон орлого	202,309,176,909.15	181,081,296,251.39	-21,227,880,657.76	-10.5%
Бусад богино хугацаат өр төлбөр	16,636,153,436.63	14,816,110,978.33	-1,820,042,458.30	-10.9%
Урт хугацаат өр төлбөр	12,669,551,078.90	15,672,867,203.94	3,003,316,125.04	23.7%
<b>Нийт өр төлбөр</b>	<b>274,097,628,886.89</b>	<b>330,620,252,047.71</b>	<b>56,522,623,160.82</b>	<b>20.6%</b>
<b>ВМЧ</b>				
Төрийн өмч	48,188,698.49	48,188,698.49	0.00	0.0%
Хувийн өмч	46,298,945.60	46,298,945.60	0.00	0.0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,876,231,609.00	5,876,231,609.00	0.00	0.0%
Хуримтлагдсан ашиг	503,356,112,181.86	281,570,922,159.62	-221,785,190,022.24	-44.1%
<b>Нийт өмч</b>	<b>509,326,831,434.95</b>	<b>281,491,641,412.71</b>	<b>-227,835,190,022.24</b>	<b>-44.7%</b>

# 2025 Орлогын дэлгэрэнгүй тайлан /аудитлагдсан, төгрөгөөр/



## Босоо шинжилгээ

### Орлогын дэлгэрэнгүй тайлан

	2024.12.31		2025.12.31		2024/2025 Өөрчлөлт
	Дүн	Хувь	Дүн	Хувь	
Борлуулалтын орлого (цэвэр)	1,158,398,002,569.03	100.0%	727,400,236,142.93	100.0%	0.0%
Борлуулалтын өртөг	589,030,425,656.49	50.8%	473,595,385,480.15	65.1%	14.3%
<b>Нийт ашиг</b>	<b>569,367,576,912.54</b>	<b>49.2%</b>	<b>253,804,850,662.78</b>	<b>34.9%</b>	<b>-14.3%</b>
Түрээсийн орлого	35,536,762.73	0.0%	0.00	0.0%	0.0%
Хүүгийн орлого	4,146,634,873.50	0.4%	2,520,816,659.19	0.3%	0.0%
Бусад орлого	2,583,139,636.12	0.2%	108,101,436.83	0.0%	-0.2%
Борлуулалт, маркетингийн зардал	4,368,300,610.58	0.4%	2,854,360,660.12	0.4%	0.0%
Ерөнхий ба удирдлагын зардал	16,575,572,532.76	1.4%	16,977,851,552.67	2.3%	0.9%
Санхүүгийн зардал	0.00	0.0%	0.00	0.0%	0.0%
Бусад зардал	2,711,170,054.27	0.2%	4,244,031,156.32	0.6%	0.3%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-3,318,263,996.03	-0.3%	10,887,408,324.79	1.5%	1.8%
Бусад ашиг (алдагдал)	0.00	0.0%	-56,610,216.52	0.0%	0.0%
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>549,159,580,991.25</b>	<b>47.4%</b>	<b>243,188,323,497.96</b>	<b>33.4%</b>	<b>-14.0%</b>
Орлогын татварын зардал	136,804,310,675.46	11.8%	60,208,157,503.05	8.3%	-3.5%
<b>Цэвэр ашиг</b>	<b>412,355,270,315.79</b>	<b>35.6%</b>	<b>182,980,165,994.91</b>	<b>25.2%</b>	<b>-10.4%</b>

# 2025 Аудитын дүгнэлт



**ОМНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРӨЙН АУДИТЫН ГЭЗЭР**  
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Данноозарга сурь, Фивентговь аймгаг, 40093  
Утас: (976) 7953 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: oimngovi@audit.gov.mn

№ 2025.03.16 № 365  
Тамгай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцэсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,409,076.5 мянган төгрөгөөр давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Санхүүгийн тайланд бүртгэлтэй нийт авлагын 33.9 хувь буюу 22,343,296.2 мянган төгрөг, урьдчилж орсон орлогын 4.9 хувь буюу 8,915,150.4 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Гаалийн мэдээ болон цахим тайлангийн системийн мэдээгээр 96,110.7 тонн нүүрс нийлүүлсэн бөгөөд худалдан авагч тал үүнээс 6,377.25 тонн нүүрсийг хүлээн аваагүй гэдэг тайлбартайгаар тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал дахь нүүрсний хөдөлгөөний мэдээ, борлуулалт тээврийн хэлтсийн борлуулалтын мэдээгээс 1,085.7 тонн жингээр зөрүүтэй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, тохиолдсон байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4626050448

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор коксжих нүүрсийг Ханги-Мандлын боомтоор экспортлох аюулыг амжилттай эхлүүлж, шинэ гарц бий болгосон байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд "Эзэмшсэн мэргэжлээрээ-Эх нутагтаа ажиллацгаая" тэтгэлэгт хөтөлбөрийн 2025-2026 оны хичээлийн жилд эдийн засагч, эрх зүйч, мэдээллийн технологи, программ хангамж, сэргээгдэх эрчим хүч, хүрээлэн буй орчны менежмент зэрэг нэн чухал мэргэжлээр сурч буй аймгийн харьяат 23 оюутанд тэтгэлэг олгосон байна.

Компанийн тухай хуулийн 76.1.18, компанийн дүрмийн 7.4.18 дах заалтыг үндэслэн нүүрсний зах зээлийн нөхцөл байдалтай холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2025 оны 2-р сарын 07-ны өдрийн 09 дугаар "Хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай" тогтоолын хүрээнд нийт ажилчдын 80.0 хувийг сул зогсолтод хамруулж, сул зогсолтын үеийн олговрыг үндсэн цалингийн 60.0 хувиар тооцож олгосон бөгөөд уурхайн үндсэн үйл ажиллагаа 2025 оны 8-р сарын 15-ны өдрөөс эхэлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаагтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд гүйцэтгэлээр 727,400,236.1 мянган төгрөгийн борлуулалтын орлого, 2,520,816.7 мянган төгрөгийн хүүгийн орлого, 108,101.4 мянган төгрөгийн бусад орлого, 10,887,408.3 мянган төгрөгийн олзыг валютын ханшийн зөрүүгээс бүрдүүлж, нийт 497,728,239.1 мянган төгрөг зарцуулан 243,186,323.5 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

**Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шавардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБЯАР

## 2025 Компанийн өгөөжийн талаар



Үзүүлэлт		2025 он	
1	Борлуулалтын орлого	мян.төг	727,400,236.14
2	Борлуулалтын өртөг	мян.төг	473,595,385.48
3	Балансын ашиг	мян.төг	253,804,850.66
4	Цэвэр ашиг	мян.төг	182,980,165.99
5	<b>Татвар хураамж</b>	<b>мян.төг</b>	<b>143,443,208.36</b>
	Өмнөговь	мян.төг	5,263,756.54
	Том татвар төлөгчийн газар	мян.төг	138,179,451.81
6	Ашгийн хувь хэмжээ	%	25.2%
7	Нэгж хувьцааны но.ашиг	төг	3,138.00
8	Ногдол ашиг	мян.төг	165,263,397.60
	Ногдол ашиг /51%/	мян.төг	84,284,332.78
	Ногдол ашиг /49%/	мян.төг	80,979,064.82
9	Хуримтлагдсан ашиг	мян.төг	17,716,768.39
10	<b>Компанийн нийт өгөөж</b>	<b>мян.төг</b>	<b>227,727,541.13</b>
	<b>Компанийн нийт өгөөж, хувиар</b>	<b>%</b>	<b>71.9%</b>




**2026 оны  
Бизнес  
төлөвлөгөө**

# 2026 оны Хөрс, нүүрс олборлолт




Хөрс хуулалтын төлөвлөлт



Хөрс хуулалт /Уурхай/	23,521.2 мян.м3
Хөрс хуулалт /ЭТТ дүйцүүлэх/	2,738.0 мян.м3
Тэсэлгээ хийх уулын цул	25,594.5 мян.м3
Нийт уулын цул	31,000.0 мян.м3
Нүүрс олборлолт	6,637.1 мян.тн
Нүүрс борлуулалт	6,730.0 мян.тн
Хөрс хуулалтын коэффициент	4.0

Нүүрс олборлолтын төлөвлөлт



# 2026 оны Голлох үзүүлэлт



№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2026 төлөвлөгөө
1	Борлуулалтын орлого	тэрбум.төг	1,916.5
	Үүнээс: Экспорт	тэрбум.төг	1,912.1
	Дотоод	тэрбум.төг	4.4
	Бусад орлого	тэрбум.төг	3.2
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	тэрбум.төг	1,119.8
	Хөрөнгө оруулалт	тэрбум.төг	75.9
	Борлуулалт, маркетинг	тэрбум.төг	6.2
	Ерөнхий удирдлага	тэрбум.төг	19.3
	Бусад зардал	тэрбум.төг	12.2
3	Татварын өмнөх ашиг	тэрбум.төг	695.2
	ААНОАТ	тэрбум.төг	173.4
	Цэвэр ашиг	тэрбум.төг	521.8
4	Төсөвт төлөх төвлөрүүлэх татвар, хураамж, төлбөр	тэрбум.төг	649.2
	Үүнээс: АМНАТөлбөр	тэрбум.төг	174.9
	Орлогын албан татвар	тэрбум.төг	173.3
	Өмнөговь аймгийн төсөвт ногдол ашиг	тэрбум.төг	226.2
	Бусад	тэрбум.төг	74.9






# АНХААРЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

☎ (+976) 7535 5555, (+976) 9500 1619

✉ [info@tavantolgoi.mn](mailto:info@tavantolgoi.mn)

📍 Хаяг: Монгол Улс, Вннеговь аймаг,  
Цагаан-Овоо баг,  
Тавантолгой хувьцаат компани



🌐 [www.tavantolgoi.mn](http://www.tavantolgoi.mn)